



## МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/41

Улаанбаатар хот

□ Байгаль орчин, геологи уул уурхайн  
хяналтын хуудас батлах тухай □

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх шинээр боловсруулсан 2.23 кодтой “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг нэгдүгээр хавсралтаар, шинэчилэн боловсруулан 2.18 кодтой “Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 2.5 кодтой “Ой ашиглалтын мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”, 2.14 кодтой “Геологи хайгуулын ажлыг шалгах хяналтын хуудас”, 2.6 кодтой “Ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 2.7 кодтой “Далд уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 2.8 кодтой “Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, 2.9 кодтой “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, худалдах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”, 2.22 кодтой “Тэсрэх материалын ашиглалтыг шалгах хяналтын хуудас”-нуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Батлагдсан хяналтын хуудаснуудыг хяналт шалгалтад хэрэглэх, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи уул уурхайн хяналтын газар, Аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын хуудас шинэчлэн баталсантай холбогдуулан Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2014 оны “Хяналтын хуудас батлах тухай” 80 дугаар тушаалаар батлагдсан 2.14 кодтой хяналтын хуудас, 2015 оны “Хяналтын хуудас батлах тухай” 540 дүгээр тушаалаар батлагдсан 2.5, 2.6, 2.7, 2.8, 2.9 кодтой хяналтын хуудас, 2015 оны 115 дугаар тушаалаар батлагдсан 2.22 кодтой хяналтын хуудаснуудыг тус тус хүчингүйболсонд тооцсугай.

4. Хяналтын хуудасны ашиглалт, хяналт шалгалтын явц, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, дүн шинжилгээ хийсэн байдалд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлага, стратеги төлөвлөлтийн газар /М.Наранбат/-түүрэг болгосугай.


ДАРГА

Н.ЦАГААНХҮҮ



09 329

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын  
2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
А/Н-1 тоот тушаалын 1 дүгээр хавсралт



**ШИНЭЭР БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАС**

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	тоо
1	2.23	Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			1

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын  
2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн  
А/НТ тоот тушаалын 2 дугаар хавсралт

### ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛСАН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Хяналтын хуудасны код	Хяналтын хуудасны нэр	тоо
1	2.18	Геодези, зураг зүйн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
2	2.5	Ой ашиглалтын мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас	1
3	2.14	Геологи хайгуулын ажлыг шалгах хяналтын хуудас	1
4	2.6	Ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
5	2.7	Далд уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
6	2.8	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
7	2.9	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, худалдах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	1
8	2.22	Тэсрэх материалын ашиглалтыг шалгах хяналтын хуудас	1
Нийт хяналтын хуудасны тоо			8